



FXB ДОРНОГОВЬ-1 ТӨСӨЛ

ЗОРИЛГО: Өрхийн орлогыг нэмэгдүүлэх, тэдгээрийг эдийн засаг, нийгмийн бие даасан байдалд хүргэх.



ХАМРАХ ХҮРЭЭ: Орано группийн 100 хувийн санхүүжилтээр Бельги Улсын “Франсуа-Ксавье Бану” ТББ-ын хэрэгжүүлж буй уг төсөлд 2016 оноос 3 жилийн хугацаанд Дорноговь аймгийн Сайншанд сумын 76, Улаанбадрах сумын 13, Зүүнбаян багийн 11, нийт 100 өрх хамрагдлаа.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: Төсөлд хамрагдсан өрхүүд нийгэм, эдийн засгийн хувьд биеэ даах арга ухаанд суралцан амьжиргаагаа дээшлүүлэх, сайхан амьдрах итгэл, урам зориг авах, цаашлаад эргэн тойрны айл өрхүүддээ дэмжлэг үзүүлэхүйц үлгэр жишээ болсоор байна.

“Төсөлд хамрагдсан 100 өрх бүгд банкинд өөрийн гэсэн хадгаламж, мөнгөн хуримтлалтай болсон.”



Ч.БАЙГАЛТУЯА

Дорноговь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

"Төсөлд хамрагдсан айлууд маань санхүүгийн мэдлэгтэй болсон, мөнгөө хуримтлуулдаг болсон, амьдрал нь дээшилсэн, хандлага нь өөрчлөгдсөн, хүүхдүүд нь боловсролынхоо чиглэлээр амжилттай суралцсан гэх мэт үр дүнгүүд маш ихээр гарсан. Төсөлд хамрагдсан 100 өрх маань амьжиргааны баталгаат түвшингээс дээгүүр орлоготой болно, хандлага нь өөрчлөгдөнө, амьдрал нь дээшилнэ гэдэг нь манай орон нутгийн хэрэгжүүлж байгаа бодлогод ихээхэн ач холбогдол өгсөн ийм хөтөлбөр байгаа юм."



Ж.ЭРДЭН ЭТУЯА

ФХВ Дорноговь Төслийн менежер

"Төсөлд хамрагдсан 100 өрх бүгд банкинд өөрийн гэсэн хадгаламж, мөнгөн хуримтлалтай болсон. Мөн манай төсөлд хамрагдсанаар хүмүүст урам зориг маш ихээр орж өөрсдийн амьдралаа сайжруулаад мөн төслөөс гарсан хойноо ч үргэлжлүүлж хөдөлмөрлөх урам зориг ордог юм байнаа гэдгийг олж харсан."

Дахин 100 өрхийг
хамруулсан ФХВ
Дорноговь-2 төсөл
2019 оны эхнээс
хэрэгжиж байна.



Төслийн явцын тухай мэдээллийг бидний
Фэйсбүүк хуудаснаас авна уу.
<https://www.facebook.com/badrakhenergy>

byambadolgor.luvsanjamts@orano.group
Бадрах Энержи ХХК
Ай Си Си цамхаг, 3-р давхар,
Жамъян гүний гудамж 9,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

Улаанбаатар, Монгол улс
Утас: +976-7011 0475
www.badrakhenergy.com
<https://www.facebook.com/badrakhenergy>
2019 оны 7-р сар